

БАТЛАВ:  
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ОРЛОГЧ Ш.ЁЛ

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМ ХУДАЛДААЧНЫ ГУДАМЖНЫ АВТО ЗАМ,  
ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ  
АЖЛЫН ДААЛГАВАР

Дугаар №ДАЗ/24-01

1. Зураг төсөл зохиох үндэслэл	- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 347 дугаар тогтоолоор баталсан Зүүн бүсийн тулгуур төв Чойбалсан хотын 2030 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө - Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт 14.6 дахь хэсэг
2. Барилга байгууламжийн байршил, чиглэл	Дорнод аймгийн Хэрлэн сумын 6 дугаар баг Худалдаачны гудамж
3. Хамрах хүрээ	Орон нутгийн чанартай авто зам
4. Зураг төслийн байгууллага	Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага
5. Зургийн үе шат, хугацаа	Гэрээнд заагдсан хугацаагаар
6. Захиалагч байгууллага	Дорнод аймгийн Засаг даргын тамгын газар
7. Төлөвлөлтийн норм	<b>Монгол Улсын хуулиуд:</b> <ul style="list-style-type: none"><li>- Авто замын тухай хууль</li><li>- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль</li><li>- Хот байгуулалтын тухай хууль</li><li>- Байгаль орчныг хамгаалах тухай хууль</li><li>- Газрын тухай хууль болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль</li><li>- Усны тухай хууль</li><li>- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль</li><li>- Бусад холбогдох хууль тогтоомжууд</li></ul> <b>Норм, нормативууд:</b> <ul style="list-style-type: none"><li>- “Авто зам төсөллөх” БНБД 32-01-07</li><li>- “Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ” БД 81-104-02</li><li>- Авто замын салбарт мөрдөх стандартын замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрлэн дохио, хашилт чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм MNS 4596:2007, 4597:2014, MNS 4980:2014: MNS 4159:2014</li><li>- Хот тосгоны төлөвлөлт, барилгажилт БНБД 30-01-04</li><li>- Усан хангамж. Гадна сүлжээ ба байгууламж БНБД 40-02-06</li><li>- Хот суурины гудамж зам төлөвлөлт /БД 32-01-04/</li><li>- Хот тосгоны нутаг дэвсгэр, зам талбайгаас бороо, цасны усыг зайлуулах ажлын зураг төсөл, тооцооны норм /БД 40-302-13/</li></ul>

<p>8. Зураг төслийн бүрэлдэхүүн</p>	<p>- Бусад холбогдох хууль тогтоомжууд</p> <p><b>Баримт бичгийн иж бүрдэл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Байр зүйн дэвсгэр зургийн тодруулга хийх</li> <li>- Холбогдох техникийн нөхцөлүүд</li> <li>- Авто зам, замын байгууламжийн инженерийн нарийвчилсан зураг төсөл</li> <li>- Зургийн тайлбар бичиг</li> <li>- Техникийн шаардлага</li> <li>- Карьерийн судалгаа</li> <li>- Геодезийн хэмжилтийн тайлан</li> <li>- Ус зайлуулах байгууламжийн тооцоо</li> <li>- Ажил гүйцэтгэх аргачлал</li> <li>- Ажлын нэр төрөл, тоо хэмжээ</li> <li>- Ажлын зураг төсөв 4 хувь, CD-ний хамт 2 хувийг захиалагчид, үндсэн хувийг архивд өгнө.</li> </ul> <p><b>Зураг төсөлд тавигдах шаардлага:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Инженерийн шугам сүлжээний ажлын зургийг УТМ-ын координатын системд хийж гүйцэтгэн батлагдсан ажлын зургийг CD-ээр Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт хүлээлгэн өгөх.</li> <li>- Ажлын зурагт бусад инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийг нэг дэвсгэр дээр нэгтгэн, хоорондын зай хэмжээг огтлолын зургаар тодорхой үзүүлж, норм стандартын дагуу төлөвлөж, инженерийн шугам сүлжээний хангагч, ашиглалч байгууллагуудтай зөвшилцсөн байх шаардлагатай.</li> </ul>
<p>9. Зургийн үе шат, хугацаа</p>	<p>Гэрээнд заагдсан хугацаагаар</p>
<p>11. Онцгой нөхцөл (Төлөвлөлтийн шаардлагаар гарах нэмэлт шаардлагууд трассын дагуух газар чөлөөлөх, хөрсний шинж чанараас хамаарсан нэмэлт төлөвлөлт, шинэ техник технологи хэрэглэх гэх мэт)</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Авто замын зургийг Монгол улсад мөрдөгдөж буй "Авто зам төсөллөх" ЗЗБНБД 22-004-2016, "Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ" БД 81-104-02, "Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм" БНБД 30.01.04, Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль" БД 31.101.04, "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар" MNS 6056-2009, "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, техникийн шаардлага" MNS 5682:20068 "Авто замын гүүр ба хоолой төсөллөх" БНБД 32-02-12, "Явган хүний зам, талбай төсөллөлт, техникийн шаардлага" MNS 6808:2019, "Авто зам, замын байгууламж. Унадаг дугуйн замыг төлөвлөхөд тавих ерөнхий шаардлага" MNS 5683:2022, "Авто зам, замын байгууламж болон инженерийн шугам сүлжээний ажлын төсөвт өртгийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн жишиг нормын дагуу тооцох, магадлалаар оруулан баталгаажуулах, ЗТХ-ийн Сайдын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 168 дугаар тушаалаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам" болон бусад хүчин төгөлдөр</li> </ul>

	<p>мөрдөгдөж буй холбогдох норм дүрмүүдийг үндэслэх.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Геодезийн хэмжилт зураглалын ажлыг улсын сүлжээний цэгүүдэд тулгуурлан хийх, зам барилгын суурь бэлтгэл ажлын хүрээнд хийгдэх тулгуур цэг байгуулах, замын төлөвлөлтийн дагуу өндрийн болон байрлалын хэмжилт хийж баталгаажуулж газрын хар өндрийг тодорхойлох.</li> <li>- Авто замын хашлага нь L хэлбэрийн хийцэл бүхий хашлагаар төлөвлөх.</li> <li>- Авто зам дагуу шаардлагатай хэсгүүдэд тунгаагуур худаг хийх.</li> <li>- Авто зам болон түүнтэй холбогдох барилга байгууламжийн угсралтын ажил гүйцэтгэхэд эдийн засгийн хувьд үр ашигтай орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтрүүлэн ашиглахаар тусгаж өгөх.</li> <li>- Авто зам дагуу одоо ус зайлуулах байгууламжуудтай холбох төлөвлөлтийг тусгах.</li> <li>- Гадаргуугийн ус зайлуулах, ус хураах талбайн хэмжээнд тооцоо хийж төлөвлөх. Борооны усны шугамын холбох цэг гаргалгааг зөв тодорхойлох, борооны ус зайлуулах шугамын хоолой, үзлэгийн болон шүүрт худаг, төлөвлөх, угсралт холболтын зургийг тодорхой тусгах.</li> <li>- Трассын дагуу огтлолцож байгаа инженерийн шугам сүлжээг хамгаалах, бэхлэх арга хэмжээг төлөвлөж, эзэмшигч байгууллагуудтай зөвшилцөх, шаардлагатай тохиолдолд шугам сүлжээг шилжүүлэх зураг, төсөв боловсруулах.</li> <li>- Зураг төсөл боловсруулах явцад ашиглагч, захиалагч байгууллагатай зөвшилцөх.</li> </ul>
12. Эдийн засгийн тооцоо, төсөв	Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох.

Хянасан:

Дорнод аймгийн ЗДТГ-ын  
ХБТХОХ-ийн дарга



/М.Нямсүрэн/

Аймгийн Ерөнхий архитектор



/А.Түмэнжаргал/

Боловсруулсан:

Дорнод аймгийн ЗДТГ-ын  
ХБТХОХ-ийн мэргэжилтэн



/Б.Урансүх/